

Эм хэрэглэх заавар

Эм хэрэглэхэд мэдэх ёстой зүйлс.

- Халуурч байгаа болон аль нэгэн өвдөлт бол 20-45 минутын дотор үр дүн илэрнэ,
- Зүрхний өвдөлт бол 5 минутын дотор намдах ёстой,
- Нянгийн халдвар бол нэг хонгийн дотор засарч эхлэх
- Даралт бол 7 хоногийн дараа 20-р буурсан байх,
- Гуурсан хоолойн багтрааны хөдлөлөөс сэргийлэх эмчилгээг үдэш,
- Ходоодны шархлааны эмчилгээнд H₂-блокаторыг үдэш,
- Зүрхний шигдээс болж болзошгүй тохиолдолд түүнээс сэргийлэх эмчилгээг өглөөгүүр,
- Зүрхний хурц дутагдал болж болзошгүй тохиолдолд түүнээс сэргийлэх эмчилгээг оройд,
- Гипертонийн кризээс сэргийлэх эмчилгээг артерийн даралтын өндөрсөлтийн үеэс 2 цагийн өмнө (ихэвчлэн 15.00-17.00 цагийн үед),
- Лейкозын эмийг 14.00-19.00 цагийн үед,
- Глюкокортикоид гормон эмчилгээний тунгийн ихэнхийг өглөөгүүр,
- Харшлын эсрэг эмчилгээг 19.00-20.00 цагийн үед тус тус хийвэл ихээхэн үр дүнтэй байдаг болох нь нотлогджээ

Эмийн талаар эмчээс заавал зөвлөгөө авах тохиолдлууд

- Өөр эмчийн бичиж өгсөн эм, чөлөөтэй зарагддаг эм (амин дэм, ходоодны хүчлийг саармагжуулах эм, өвчин намдаах эм, ханиалга, ханиадны эсрэг эм, өтгөн хаталтын эсрэг эм г.м.), уламжлалт анагаахын эмүүд зэрэгийг хамтруулж ууж байгаа тохиолдолд
- Пиво, архи зэрэг согтууруулах ундаа тогтмол хэрэглэж байгаа тохиолдолд.

Дараах зүйлийг **Эмчээсээ** заавал тодруулан асууж байх:

- Эм ямар үйлдэлтэй
- Эм хэрэглэхэд биед ямар өөрчлөлт гарч болох?
- Ямар гаж нөлөө гарч болох ?
- Эм уух хугацаанд юуг анхаарах? (тодорхой нэг хоол хүнс, шингэнийг хэрэглээнээсээ түр хугацаагаар хасах шаардлагатай юу, бусад эмийг хэрэглэхээ болих уу, машин барьж болох уу г.м.)
- Эмийг хэдий хугацаагаар уух?,

Эмийг зохистой хэрэглэх заавар

Хийх ёстой зүйлс:

- Эмийг эмчийн зөвлөгөө болон “Хэрэглэх заавар”-ын дагуу тохирох тунгаар, хэрэглэх цагаар, зөвлөсөн хоногийн турш зөв хэрэглэх.
- Эмийг хэрэглэхийн өмнө тухайн эмийн эмчилгээний үйлдэл, үндсэн үйлчлэгч бодис, хэрэглэх заалт, гаж нөлөө, цээрлэл, өдөрт хэдэн удаа, хэд хоног, ямар тунгаар хэрэглэх талаар тодорхой мэдээлэл авсны дараа хэрэглэх.
- Ямар нэг гаж нөлөө гарвал эмчид ханд
- Эм уусан талаараа өдөр бүр тэмдэглэгээ хийж байх хэрэгтэй.

- Шингэн эмийг уухдаа савны хаягтай хэсгийг дээш нь харуулж эмийг хэрэглэх хэрэгтэй. Эмийг хэрэглэж дуусахаас өмнө хаяг нь унахаас болгоомжилж байх. Мөн бичиг нь арилах магадлалтай бол хадгалах талаар анхаарах хэрэгтэй.
- Эмийг хүүхэд хүрэхээргүй газар тавих.
- Хэт олон эмийг нэг дор хэрэглэхгүй байх, зөвхөн шаардлагатай цөөн эм хэрэглэх.
- Хүүхдэд эм хэрэглэхдээ зөвхөн эмчийн заавраар өгөх.
- Жирэмсэн үед ялангуяа эхний 3 сард эмийг аль болох хэрэглэхгүй байх нь зүйтэй. Хэрэв шаардлагатай бол эмчийн заавраар хэрэглэх.
- Эмийг өөрийнх нь саванд хадгалах нь чухал. Зарим эм бараан саванд хадгалах зориулалттай байхад заримыг нь зөвхөн шилэн саванд хадгалах хэрэгтэй байдаг.
- Эмийг буруу хадгалснаас хугацаа нь дуусаагүй боловч эмчилгээний үйлдэл нь буурч, чанараа алдан эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлдэг тул эмийн шошго дээр заасан нөхцөлд зөв хадгалах

Хийж болохгүй зүйлс:

- Эмчээс асуулгүйгээр хэд хэдэн эм хольж уух
- Урьдны өвчинтэй шинж тэмдэг нь ижил байсан ч өмнө нь ууж байсан эмээ одооны өвчинд тохирно гэж үзэх.
- Өвчний шинж тэмдэг адил байсан ч бусдад бичиж өгсөн эмийг дуурайж уух, өөрийн ууж байгаа эмээ бусдад өгөх. Нэг эм хүн хүнд өөр өөр үйлдэл үзүүлж болдог.
- Харанхуйд эм уух. Эм уухын өмнө эмийн нэрийг гэрэлтэй газар шалгаж хэвших.
- Хугацаа дууссан эмийг хадгалах. Ийм эмийг хүүхдэд очихоос сэргийлж жорлонд хийж усыг нь татах
- Хугацаа нь хэтэрсэн эмийг бүү хэрэглэ.

Жор бичих

Эмчийн бичсэн жорыг эм баригч бичсэн жорын дагуу өвчтөнд зөв олгох ёстой.

Эм баригч гэдэг нь эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг найруулах, савлан бэлтгэх, шалган олгох үйл ажиллагааг эрхэлдэг, зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтнийг хэлнэ.

Эм баригчийн үүрэг:

- * Эмийг өвчтөнд олгохдоо уг эмийг хэрэглэх арга, давтамж, тун хэмжээ, хэрэглэх хугацаа, илэрч болох гаж нөлөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгнө.
- * Жор хүлээн авсан, бэлтгэсэн, шалгасан, олгосон эм баригч жорын маягтын ар талд шарын үсэг зурж огноог тэмдэглэнэ.
- * Мансууруулах эмийн жорын маягтын ар талд эм хүлээн авсан хүний нэр, хаяг, регистрийн дугаар, огноог тэмдэглэж гарын үсэг зуруулна.

Эмийн жор бичихдээ **“Эмийн жорын маягт, жор бичилт”** монгол улсын стандартыг баримтална.

Энгийн жорын маягтад 3-аас илүүгүй, мансууруулах жорын маягтад 1-ээс илүүгүй эм бичнэ.

Хөнгөвчлөх эмчилгээнээс бусад мансууруулах жорын маягтад 10-аас ихгүй үрэл, шахмал, лаа, түншил, 20-иос ихгүй шингэн эм бичнэ.

Эмийн жор бичих дүрэм:

- Эмийн жорыг бэх болон тосон балаар тод гаргацтай засваргүй бичнэ.
- Эм биобэлдмэлийн нэрийг латин том үсгээр эхлэн харъяалахын тийн ялгалд бичнэ. Жор олон найрлагатай бол бүгдийг шинэ мөрнөөс бичих ба том үсгээр зэрэгцүүлэн бичиж, ард нь тунг бичнэ.
- Шингэн эмийн хэмжээг миллитр, дуслаар бол X.gttс, бусад эмийн хэлбэрийг граммаар илэрхийлнэ.
- Жорын хуудсанд 0-16 насны хүүхэд, 60-аас дээш насны хүмүүсийн насыг бичнэ.
- Жорын хуудсанд хэд хэдэн эмийн жор бичвэл хооронд нь тусгаарлах тэмдэг # тавина.
- Хэрэв нэг жорын найрлагат хэд хэдэн эмийн бодисын тун адил байвал тус бүрийн ард тунг бичихгүй, харин хамгийн суулийн эмийн бодисын ар талд аа гэж товчлон бичээд тунг нэг бичнэ.
- Өвчтөнд эмийг яаралтай олгох шаардлагатай үед жорын хуудасны зүүн дээд талд Cito! (яаралтай) буюу Statim(нэн даруй)! Гэж бичнэ.
- Эмч өөртөө жор бичих тохиолдолд өөртөө буюу pro me гэж тусгайлан тэмдэглэсэн байна.
- Жорын хуудсанд нэг удаа спиртийн уусмал ба эмнэлгийн цэвэр спиртийг 50-мл-ээс илүү бичихийг хориглоно.
- Эм биобэлдмэлийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй болон зөвхөн эмнэлгийн нөхцөлд хэрэглэх зориулалттай эмийг жорд бичихийг хориглоно.
- Хэрэв эмч онцгой шаардлагаас шалтгаалан эмийг стандарт дундаж тунгаас их хэмжээгээр бичих аваас эмийн тунгийн ард анхаарлын тэмдэг тавих буюу тунг үсгээр бичиж, тамга дарж баталгаажуулна.
- Мансууруулах болон сэтгэц нөлөөт болон бусад эмийн жор 10 хүртэлх хоногийн хугацаанд хүчинтэй.
- Буруу бичигдсэн эмийн жорыг эмийн сан, жор бичсэн эмчийн эмнэлгийн байгууллагын захиргаанд албан ёсоор хүргүүлнэ.
- Жорын хуудсыг аймаг, хотын засаг даргын тамгын газар эрхэлж батлагдсан загварын дагуу хэвлүүлж, улсын болон хувийн эмнэлгийн байгууллагуудад хувиарлан олгож жор бичилт, хуудасны зарцуулалатанд хяналт тавьж тооцоо хийнэ.
- Мансууруулах эмийн жорын хуудас нь эрхэлсэн байгууллагын тамга дарж баталгаажсан байхаас гадна жор бичсэн эмч, эмнэлгийн байгууллагын тамга, гарын үсэгтэй байж хүчин төгөлдөрболно.
- Олон найрлагатай эмийн жорыг бичихдээ найрлагат орсон эмийн бодисыг ач холбогдлоор нь дэс дараалуулж бичнэ. Эхэнд эмийн гол үйлдэл үзүүлэх

бодис, 2-т туслах бодис, 3-рт үнэр, амт засах бодис, сүүлд нь хэлбэр оруулах бодисыг тус тус бичнэ.

Эмийн жор бичих бүтэц:

Inscripto: эмнэлгийн нэр, онош, эмч, өвчтөний овог нэр, нас, хүйс, жор бичсэн он.сар.өдөр

Designation: эмийн нэр, тун

Subscriptio: эмийн хэлбэр бэлтгэх арга, нийт тоо хэмжээ

Signature: эмийн хэрэглэх аргыг заах

Жор хүлээн авах, журмын дагуу эм олгох

1. ЭМСайдын 2005 оны №171:

- Тусгай жороор олгох эм
- Ердийн жороор олгох эм 356 эм, 41 уламжлалт эм

2. Зохистой хэрэглээний талаас:

- ◇ Тун хэмжээ тохирсон эсэх: биеийн жинд тохирсон тун, хоногийн тун
- ◇ Хэрэглэх арга: хоолны өмнө дараа, ус, жүүс гэх мэт
- ◇ Харилцан нөлөөлөл: Парацетамол, индометацин, септрин, гентамицин гэх мэт
- ◇ Тухайн өвчтөнд тохирох эсэх: Жирэмсэн үед, хүүхдэд, өндөр настанд, багтраатай хүнд г.м.

3. Олгох тоо ширхэгийг тохируулна:

- Ердийн эмийг савлагдсан хэмжээгээр нь олгоно (ээлж эмчилгээний тун байж болно).
- Шинж тэмдгийн эмийг ширхэгээр олгож болно.
- Хортой, хүчтэй эмийг 10 ширхэгээс илүүгүй олгоно,

2. Савлалт, шошгололт шаардлага хангасан байх:

- Эмийн нэр, савлалтын тун, хэрэглэх тун, хадгалах нөхцөл, хадгалах хугацаа, цувралын дугаар.

Зөвөлгөө өгөх

1. Эмийг хэрэглэх аргачлал:

- Нэг удаагийн тун, Хоногийн тун,
- Хэзээ хэрэглэх: өглөө, орой, хоолны өмнө, дараа г.м.

1. Эм тохирсон эсэхийг үнэлэх

- Тухайн эм өвчинд тохирох эсэхийг асуух
- Эмийн бүлгийн зөв, үр дүнтэй, хоргүй эм сонгоход нь туслах

3. Гаж нөлөөний талаар:

- 1 эм хэрэглэж байгаа үед 20% орчим,
- 2 эм хэрэглэх үед 40% орчимд гаж нөлөө илэрдэг.

4. Хэрхэн хадгалах талаар:

- Тохиромжтой хэмд хадгалах:

- Ердийн нөхцөл: 18-20 хэм буюу тасалгааны хэмд,
- Сэрүүн газар: 18-12 хэмд.
- Хөргөгчинд: ...
- Хүүхэд хүрэхгүй газарт хадгалах:

Мэдлэг шалгах тест

1. Эм хэрэглэх ерөнхий аргуудыг сонго
 - A. Уух
 - B. Тарих
 - C. Эм
 - D. Хоолны өмнө ууна.
2. Эмийн зохистой хэрэглээний үндсэн зарчимд алин орох вэ?
 - A. “Хэрэглэх заавар”-ын дагуу тохирох тунгаар, хэрэглэх цагийг нарийн баримтлан, зөвлөсөн хоногийн турш зөв хэрэглэх
 - B. Урьдны өвчинтэй шинж тэмдэг нь ижил байсан ч өмнө нь ууж байсан эмээ одооны өвчинд тохирно гэж үзэх.
 - C. Хэт олон эмийг нэг дор хэрэглэж болно, учир хурдан эдгэнэ
 - D. Хүүхдэд эм хэрэглэхдээ заавал эмчийн зөвөлгөө хэрэггүй.
3. Эм баригчийн үүрэг нь аль вэ?
 - A. Эм олгох
 - B. Эм худалдах
 - C. эмийг хэрэглэх арга, давтамж, тун хэмжээ, хэрэглэх хугацаа, илэрч болох гаж нөлөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгөх хүн
 - D. эмийг хэрэглэх арга, давтамж, тун хэмжээ, хэрэглэх хугацаа, илэрч болох гаж нөлөөний талаар заавал тайлбарлах албагүй эм олгодог хүн
4. Эм баригчийн үүрэг аль нь биш вэ?
 - A. Эмийг өвчтөнд олгохдоо уг эмийг хэрэглэх арга, давтамж, тун хэмжээ, хэрэглэх хугацаа, илэрч болох гаж нөлөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгнө.
 - B. Жор хүлээн авсан, бэлтгэсэн, шалгасан, олгосон эм баригч жорын маягтын ар талд шарын үсэг зурж огноог тэмдэглэнэ.
 - C. Мансууруулах эмийн жорын маягтын ар талд эм хүлээн авсан хүний нэр, хаяг, регистрийн дугаар, огноог тэмдэглэж гарын үсэг зуруулна.
 - D. Эм зүйн шинжлэх ухааны дагуу эмийг найруулах, савлан бэлтгэх, шалган олгох үйл ажиллагааг эрхэлдэг, зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн
5. Эмийн энгийн жор бичих маягтад хэдэн эм бичихийг хуулиар зөвшөөрсөн байдаг вэ?

- A. 10
- B. 6
- C. 8
- D. 3

6. Эмийн жор бичих дүрэмд алин нь орохгүй вэ?
- A. Эм биобэлдмэлийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй болон зөвхөн эмнэлгийн нөхцөлд хэрэглэх зориулалттай эмийг жорд бичихийг хориглоно.
 - B. Хэрэв эмч онцгой шаардлагаас шалтгаалан эмийг стандарт дундаж тунгаас их хэмжээгээр бичих аваас эмийн тунгийн ард анхаарлын тэмдэг тавих буюу тунг үсгээр бичиж, тамга дарж баталгаажуулна.
 - C. Мансууруулах болон сэтгэц нөлөөт болон бусад эмийн жор 10 хүртэлх хоногийн хугацаанд хүчинтэй.
 - D. Тухайн өвчтөнд тохирох эсэх: Жирэмсэн үед, хүүхдэд, өндөр настанд, багтраатай хүнд г.м.
7. Эмийн жорын хуудсанд спирт болон эмнэлгийн спиртыг нэг удаа хичнээн мл бичиж болно гэж заасан байдаг вэ?
- A. 50 мл
 - B. 100 мл
 - C. 150 мл
 - D. 200 мл
8. Олон найрлагатай эмийн жорыг бичихдээ найрлагат орсон эмийн бодисыг ач холбогдлоор дараалуулж бичнэ.
- A. 1-т гол бодис, 2-т туслах бодис, 3-рт үнэр, амт засах бодис, 4-т хэлбэр оруулах бодис
 - B. 1-т туслах бодис, 2-рт үнэр, амт засах бодис, 3-т хэлбэр оруулах бодис
 - C. 1-т гол бодис, 2-рт үнэр, амт засах бодис, 3-т туслах бодис, 4-т хэлбэр оруулах бодис
 - D. 1-рт үнэр, амт засах бодис, 2-т хэлбэр оруулах бодис, 3-т гол бодис, 3-т туслах бодис
9. Эмийн бэлдмэлийн хадгалах нөхцөлүүдээс зөвийг сонго.
- A. Зүрхний шигдээс болж болзошгүй тохиолдолд түүнээс сэргийлэх эмчилгээг өглөөгүүр,
 - B. Зүрхний хурц дутагдал болж болзошгүй тохиолдолд түүнээс сэргийлэх эмчилгээг оройд,
 - C. Гипертонийн кризээс сэргийлэх эмчилгээг артерийн даралтын өндөрсөлтийн үеэс 2 цагийн өмнө
 - D. Ердийн нөхцөл: 18-20 хэм буюу тасалгааны хэмд
 - E. Ердийн нөхцөл: 25-36 хэм буюу тасалгааны хэмд

10. Судсанд тарих хүчтэй биш үйлдэлтэй эмийг 1 минутанд хэдэн миллилитр орохоор тооцох вэ?
- A. 0.5- 1 мл
 - B. 1- 2 мл
 - C. 2-4 мл
 - D. 3- 4 мл
 - E. 4- 5 мл
11. Дараахаас эм тохирсон эсэхийг зөв үнэлсэнийг сонго.
- A. Шинж тэмдгийн эмийг ширхэгээр олгож болно.
 - B. Хортой, хүчтэй эмийг 10 ширхэгээс илүүгүй олгоно
 - C. Тодорхой нэг эмийг хэрэглэсний дараа арьс загатнах, ходоод хямрах, толгой эргэх, нүд бүрэлзэх зэрэг гаж нөлөө илэрсэн тохиолдолд
 - D. Даралт бол 7 хоногийн дараа 20-р буурсан байх,
12. Дараах хариултуудаас аль нь эмийн гаж нөлөө вэ?
- A. Даралт бол 7 хоногийн дараа 20-р буурсан байх,
 - B. Гуурсан хоолойн багтрааны хөдлөлөөс сэргийлэх эмчилгээг үдэш,
 - C. Ходоодны шархлааны эмчилгээнд H₂-блокаторыг үдэш
 - D. Арьс загатнах, ходоод хямрах, толгой эргэх, нүд бүрэлзэх зэрэг
13. Эмийн ямар гаж нөлөө тунгаас хамаарахгүй вэ?
- A. Эмийн фармакологийн үйлдэлтэй холбоотой бол
 - B. Туйлын буюу харьцангуйгаар тун хэтрүүлснээс нөхцөлдсөн хордуулах нөлөөнөөс шалтгаалсан бол
 - C. Бие мах бодын иммунобиологийн өөрчлөлтөөс нөхцөлдсөн дам эффект
 - D. Хурдан ба удаан явцат иммунийн урвал
 - E. Эмийг гэнэт зогсоосноос үүсэх хам шинж
14. Дараах эмүүдийн аль нь хатуу эмийн хэлбэрт хамаарагдахгүй вэ?
- A. Шахмал эм
 - B. Нунтаг эм
 - C. Лаа хэлбэрийн эм
15. Эм хэрэглэх хамгийн зохимжтой аргыг нэрлэнэ үү?
- A. Судсанд тарих
 - B. Уух
 - C. Шулуун гэдсээр хэрэглэх
16. Дараах эмүүдийн аль нь зөөлөн эмийн хэлбэрт хамаарагдахгүй вэ?
- A. Тосон түрхэц
 - B. Холимог шингэн
 - C. Үтрээний лаа
17. Дараах эмүүдийн аль нь хатуу эмийн хэлбэрт хамаарагдах вэ?
- A. Бүрээстэй эм

- B. Хандмал эм
- C. Мөхлөг эм
- D. Үрлэн эм

18. Дараах эм хэрэглэх аргуудын аль нь хоол боловсруулах замаар эм хэрэглэх аргад хамаарагдах вэ?

- A. Дусал
- B. Хэлэн дор тавьж хэрэглэх
- C. Үтрээгээр шахмал эм хэрэглэх арга
- D. Тарих
- E. жигнэх

19. Тосонд уусдаг витаминь бэлдмэлийг нэрлэнэ үү?

- A. Рибофлавин
- B. Пиренцепин
- C. Эргокальциферол
- D. Бендазол
- E. Резерпин

20. Усанд уусдаг витаминь бэлдмэлийг нэрлэнэ үү?

- A. Эналаприл
- B. Аскорбины хүчил
- C. Токоферол
- D. Бендазол
- E. Резерпин

Сорилын хариу

1C 2A 3C 4D 5D 6D 7A 8A 9D 10C 11D 12D 13E 14C 15B 16B 18A 19B 20B